



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 10 өдөр

Дугаар A/358

Улаанбаатар хот

Г Захирамжийн холбогдох заалтад
өөрчлөлт оруулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.2 дахь хэсэг, Засгийн газрын 2021 оны 118 дугаар тогтоол, Нийслэлийн Онцгой комиссын 2021 оны 08 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/357 дугаар захирамжийн 3.4-т “Үйл ажиллагааг нь хязгаарлахгүй төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийн ажилтан, албан хаагчдын хувийн болон албаны тээврийн хэрэгслийг улсын дугаарын сүүлийн орон тэгш, сондгой тоогоор төгссөнөөр хуанлийн өдрөөр (хүнс, эмнэлгийн тусламж үйлчилгээ, буяны үйлчилгээ, инженерийн байгууламж, хот нийтийн аж ахуйн ажил, хэвлэл мэдээлэл, тусгай зориулалтын тээврийн хэрэгслээс бусад) 06:00-22:00 цагт замын хөдөлгөөнд оролцуулж, түгжрэл saat ал үүсгэхгүй байх, хариу арга хэмжээ авч ажиллах” гэснийг “Нийслэлийн нутаг дэвсгэрт тээврийн хэрэгслийг ажлын өдрүүдэд дугаарын хязгаарлалтаар замын хөдөлгөөнд оролцуулж, түгжрэл saat ал үүсгэхгүй байх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах” гэж өөрчилсүгэй.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ Д.СУМЬЯАБАЗАР